3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гадаад харилцааны яам нь “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тус яам нь эрхэм зорилгоо биелүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд, тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, таатай гадаад орчин бүрдүүлэх,
- Монгол орны хөгжлийг хангах таатай орчин бүрдүүлэх,
- Монгол улсын иргэдийн эрх ашиг, бизнесийн ашиг сонирхлыг хилийн чандад хамгаалах,

Гадаад харилцааны яамны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Засгийн газрын 2016 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 3 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны бүтэц, орон тооны хязгаарыг 142 байхаар баталсныг Засгийн газрын 2019 оны 65 дугаар тогтоолоор орон тоог 147 болгосон байна.

Гадаад харилцааны яам нь 2020 оны жилийн эцсийн байдлаар улс төрийн албан тушаалтан 2, төрийн тусгай албан хаагч /дипломат ажилтан/ 113, төрийн захиргааны албан хаагч 15, төрийн үйлчилгээний албан хаагч 14, гэрээт ажилтан 2, нийт 147 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулан ажиллаж ирсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Засгийн газрын тогтоолууд

- Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам батлах тухай /2020 №190/
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай /2020 №203/
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам /2020 №206
- Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам /2020 №216/
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам /2020 №217/
- Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам /2020 №218/

Хуулиуд

- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /2020.04.24/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020.05.07/

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гадаад харилцааны яамны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь Гадаад харилцааны яамны санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд дотоод хяналт хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 13,749,073.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 137,490.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гадаад харилцааны яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 529,550.8 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,039.2	4,246.1	-6,793.1
Авлага	332,037.5	283,882.1	-48,155.4
Урьдчилгаа	82,266.2	18,980.0	-63,286.2
Бараа материал	148,986.1	332,135.8	183,149.7
Үндсэн хөрөнгө	10,873,441.9	10,278,976.2	-594,465.7
Нийт хөрөнгө	11,447,771.1	10,918,220.3	-529,550.8
Өр төлбөр	112,133.4	29,277.2	-82,856.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,335,637.6	10,888,943.1	-446,694.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,447,771.1	10,918,220.3	-529,550.8

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,246.1 мянган төгрөг болж 6,793.1 мянган төгрөгөөр буурсан нь кассын үлдэгдэл болон нэмэлт санхүүжилтийн данстын үлдэгдэл буурснаас шалтгаалжээ. Энэ нь өмнөх оны кассын үлдэгдлийг тухайн онд татан төвлөрүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласнаар үлдэгдэл буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 283,882.1 мянган төгрөг болж 48,155.4 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага болон хувь хүмүүсээс авах авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2009-2014 онуудад үүссэн, он удаан жил болсон дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтай холбоотой 96,672.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага 24,137.0 мянган төгрөгийн томилолт, дараа тайлангийн авлагууд байна.

Нийт авлагаас тооцоо нийлсэн актаар баталгаажуулах 120,809.2 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс барагдах боломжгүй эрсдэлтэй 24,137.0 мянган төгрөгийн авлага байна.

Урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдэл 63,286.2 мянган төгрөгөөр буурсан нь "Галт хан" мэдээллийн аюулгүй байдлын программын лицензийн урьдчилгаа төлбөрийн тайлант онд ноогдох дүн байна.

Бараа материалын зардлын дансны үлдэгдэл 332,135.8 мянган төгрөг болж 183,149.7 мянган төгрөг болж өссөн нь тусгай зориулалтын материал буюу цахим болон энгийн е-паспорт 193,808.7 мянга, бичиг хэргийн материал 61,390.6 мянга, аж ахуйн материал 2,134,454.1 мянга, барилгын засварын материал 222,588.6 мянга, бусад хангамжийн материал 224,832.8 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,278,976.0 мянган төгрөг болж 594,465.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс урсгал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 161,054.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн, 755,520.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлын дүнгээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 29,277.2 мянган төгрөг болж 82,856.2 мянган төгрөгөөр буурсан нь Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар УТҮГ-т өгөх 58,558.4 мянган төгрөгийн шатахууны зардлын өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Өглөгийн дансны үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй, байгууллага, хувь хүмүүст өгөх 29,277.2 мянган төгрөгийн өглөг байна. Өглөгийн үлдэгдэлд анхаарал хандуулан барагдуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,888,943.1 мянган төгрөг болж 446,694.5 мянган төгрөгөөр буурсан нь бараа үйлчилгээний бусад зардал өсч тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

Орлого өмнөх оноос 212,845.7 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан туслах үйл ажиллагааны орлого covid-19 цар тахалтай холбоотойгоор 2,043,403.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 537,406.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цалингийн зардал 441,611.0 мянга, НДШ-ийн зардал 139,895.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,837,867.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус тус 15,762,421.1 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,120,977.7 мянган төгрөгөөр бууруулж 13,641,443.4 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс үзэхэд төсвийн захирагч төсвийг бодитой төлөвлөөгүй гэж үзэхээр байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн хүрээнд 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,641,443.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 12,091,443.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 560,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор, 990,000.0 мянган төгрөгийг олон улсын хамтын ажиллагааны сангийн үндсэн үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,470,632.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 107,525.2 мянган төгрөг, нийт 9,578,157.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 7,196,639.4 мянган төгрөгийг зарцуулж 2,381,518.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,196,639.4 мянган төгрөг буюу 52.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 468,104.8 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 261,846.4 мянга, томилолтын зардлыг 734,076.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,742,629.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,621,770.5 мянга, тэтгэмж урамшуулал, урсгал шилжүүлэг 1,237,279.0 мянган төгрөгөөр тус тус зарцуулаагүй үлдсэнтэй холбоотой байна.

Гадаад харилцааны яам тайлант онд 560,000.0 мянган төгрөгийн төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого олж санхүүжихээр батлагдсанаас гүйцэтгэлээр 107,525.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 452,474.8 мянган төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөг тасалсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны 1,550,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 107,525.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,442,474.8 мянган төгрөг буюу 93.0 хувиар баталсан төлөвлөгөөг тасалсан байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	560,000.0	107,525.2	452,474.8	80.8
Үндсэн үйл ажиллагааны орлого	990,000.0	-	990,000.0	0.0
Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын нийт дүн	1,550,000.0	107,525.2	1,442,474.8	93.0

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 492,246.2 мянган төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 2,959,480.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 121,842.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 41,334.5 мянга, нийт 3,614,902.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, НДШ-д 68,541.9 мянга, хангамж, бараа материалд 4,136.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 88,690.3 мянга, томилолтын зардалд 2,564.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 130,919.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,985,870.0 мянга, нийт 3,417,649.9 мянган төгрөгийг зарцуулжээ. Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдэгдэл 4,471.6 мянган төгрөг байсан бол 3,614,902.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 3,417,649.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 201,724.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 144 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 20,487.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 4 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн. Үүнээс төлбөрийг актыг барагдуулж, албан шаардлагын хэрэгжилт 80.0, зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	20,487.0	4	20,487.0			100.0
Албан шаардлага	1	-			1	-	80.0
Зөвлөмж	5	97,858.7	4	23,705.3	1	74,153.4	90.0
Нийт дүн	10	118,345.7	8	44,192.3	2	74,153.4	90.0

Хэрэгжүүлээгүй 74,153.4 мянган төгрөгийн 1 зөвлөмжид албан шаардлага хүргүүлэв.

ГХЯ-тай “ХӨМОТЭ” ХХК нь гэрээ байгуулан “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилгын ажил 2013 оноос баригдаж эхэлсэн ба 2017 онд ашиглалтад ороход бэлэн болсон боловч дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 4 жил болсон бөгөөд одоогоор улсын комисс хүлээн авсан шийдвэр гараагүй, тус компанитай шүүхийн маргаантай, эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,100.689.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 351,724.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 145,435.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 1,603,529.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсээс орлогыг 127,724.3 мянган төгрөгийн хандив тусламжийг хүлээн авч, мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсныг залруулав.
2. Хилийн чандад байгаа монгол иргэдэд туслах сангийн 224,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн зарцуулалтыг ГХЯ-ны аппаратын тайланд нэгтгэн тайлагнаж, аудит хийлгэсэн боловч ТЭЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд Хилийн чандад байгаа монгол иргэдэд туслах сангийн санхүүгийн тайланг салгаж, нэгтгэсэн байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 145,435.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд 283,882.0 мянган төгрөгийн авлага, 29,277.2 мянган төгрөгийн өглөг үүссэнээс 120,809.1 мянган төгрөгийн авлага, 24,626.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 5,654,253.4 мянган төгрөгийн 144 мэдээлэл мэдээлэхээс, 136 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан...журам...-д гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,603,529.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

АНУ-д хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай Засгийн газрын 209 дүгээр тогтоолын дагуу ГХЯ хамгаалалтын хувцас/комбинезон/ худалдан авахаар Эксклюкиви Медикал ХХК-аас 400,000.0 мянган төгрөг, Мөнхийн тун ХХК-аас 1,727,250.0 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус хийхдээ холбогдох албан тушаалтны шийдвэр гаргаагүй, шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Олон улсын хамтын ажиллагааны санд үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн зарцуулах эрхтэйгээр 990,000.0 мянган төгрөгийн төсөв төлөвлөн батлуулсан боловч зарцуулалт гаргаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийг үнэн зөв бодитой төлөвлөөгүйгээс үргүй зардал гарах;

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийг үнэн зөв, бодитой төлөвлөж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2.Төсвийн орлоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

ГХЯ-ны төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,550,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 1,442,474.8 мянган төгрөгийг орлого тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, төсвийн орлого тасрах, холбогдох хууль журам зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг үнэн зөв бодитой төлөвлөх, орлогын бүрэн төвлөрүүлэн талаар анхаарч ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.Зардалтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Урсгал зардлаас нийт 161,054.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Холбогдох хууль тогтоож зөрчигдөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсвийг хэтрүүлэн зарцуулсан байх;

3.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль тогтоомж хэрэгжүүлэн ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021.02.25			САГ-2021/335/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гадаад харилцааны яам		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Олон улсын хамтын ажиллагааны санд үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн зарцуулах эрхтэйгээр 990,000.0 мянган төгрөгийн төсөв төлөвлөн батлуулсан боловч зарцуулалт гаргаагүй хоёр жил болсон байна.	990,000.0	Зөвлөмж өгөх	ТНБ-ийн дарга, СЭЗХ-ийн дарга, Нягтлан бодогч	Н.Анхбаяр Х.Алтантуяа С.Алтангэрэл
2	ГХЯ-ны төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,550,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс үндсэн үйл ажиллагааны орлого 990,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 560,000.0 мянган төгрөг тус тус батлуулан гүйцэтгэлээр 107,525.2 мянган төгрөг төвлөрүүлж, 452,474.8 мянган төгрөгийг орлого тасарсан байна.	452,474.8	Зөвлөмж өгөх	ТНБ-ийн дарга, СЭЗХ-ийн дарга, Нягтлан бодогч	Н.Анхбаяр Х.Алтантуяа С.Алтангэрэл
3	Тайлант онд 283,882.1 мянган төгрөгийн авлага, 29,277.2 мянган төгрөгийн өглөг үүссэнээс 120,809.2 мянган төгрөгийн авлага, 24,626.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй байна.	145,435.3	Албан шаардлага өгөх	СЭЗХ-ийн дарга, Нягтлан бодогч	Х.Алтантуяа С.Алтангэрэл
4	Урсгал зардлаас нийт 161,054.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.	161,054.9	Зөвлөмж өгөх	ТНБ-ийн дарга, Нягтлан бодогч	Н.Анхбаяр С.Алтангэрэл
5	Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 5,654,253.4 мянган төгрөгийн 144 мэдээлэл мэдээллээс, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага өгөх	ТНБ-ийн дарга, СЭЗХ-ийн дарга,	Н.Анхбаяр Х.Алтантуяа
ДҮН		1,748,965.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 75/АД/170076
САГ-002/335/СТА-ТЧЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гадаад харилцааны яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 283,882.0 мянган төгрөгийн авлага, 29,277.2 мянган төгрөгийн өглөг үүссэнээс 120,809.1 мянган төгрөгийн авлага, 24,626.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөг барагдуулж ажиллах, нэмж үүсгэхгүй байх, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа, нягтлан бодогч С.Алтангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.ОТГОНХОРЛОО



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 76/А0170076
САН-2021/335/СТА-ТЧЗ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гадаад харилцааны яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 144 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

Төсөв гүйцэтгэлийн талаар мянган төгрөгийн 1, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын хийгдээгүй талаар 1, Бусад шийдвэр үйл ажиллагааны байгууллагын батлагдсан төсөв 2, 2021 оны төсвийн төсөл 2, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл талаар 1 зэрэг мэдээлэл тус тус байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.7-д "Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа, Нягтлан бодогч С.Алтангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

С.ОТГОНХОРЛОО